

АНГЛИ ХЭЛНИЙ ОРЧУУЛГЫН ДАДАЛ ХИЧЭЭЛД СОНИН ХЭВЛЭЛИЙН МАТЕРИАЛ АШИГЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛ

У. Лхагвасүрэн¹

Англи хэлний орчуулгын дадал хичээлд бид сонин, сэтгүүл, интернетийн мэдээ, сурах бичиг, гарын авлага, толь бичиг, уран зохиол, тайлбар толь, нэвтэрхий толь, англи-монгол ба монгол-англи хэлний толь бичиг, аудио видео материал, хуурцаг, кино зэрэг олон эх сурвалжаас авсан мэдээ, мэдээлэл, бичвэрүүдийг ашигладаг.

Орчуулгын хичээлд хэрэглэх материалд дүн шинжилгээ хийх нь хичээлийн бэлтгэл ажлын хамгийн чухал хэсэг юм. Юуны өмнө тухайн эх материалыг хэл зүй, найруулга зүй, үг зүйн талаас нь сайтар судлах хэрэгтэй.

Судалгааны үр дүнд эх сэдвийн бүтцийг тодорхойлохоос гадна ямар алдаа дутагдал, ташаарал байгааг олж тогтооход дөхөмтэй байдгаараа чухал ач холбогдолтой байдаг ажээ.

Хэрвээ эх сэдэв алдаатай байвал орчуулга алдаатай болно. Эх сэдвийн найруулга ойлгомжгүй, ташаарсан байвал орчуулга нь ч мөн алдаатай болдог.

Олон улсын харилцаа болон олон улсын эдийн засгийн харилцааны чиглэлээр суралцагч оюутанд орчуулгын дадал хичээл онцгой ач холбогдолтой байдаг. Дэлхийн улс орнуудын улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдралд гарч буй үйл явдлуудын талаар мэдээ мэдээллийг орчуулгын хичээлд ашиглах нь нэг талаас тухайн сэдвийн хүрээнд оюутны үгсийн сангийн мэдлэгийг баяжуулах, нөгөө талаас оюутны мэдлэгийн хүрээг өргөжүүлэхэд тустай байдаг.

Орчуулгын дадал хичээлд хэрэглэх эх сэдвийг бид өдөр тутмын сонин хэвлэлээс авч бэлтгэдэг. Монгол хэлнээс англи хэлэнд орчуулах мэдээллийг бид голчлон “Өдрийн сонин”-ы “Дэлхийн мэдээ” булангаас авдаг юм. Хэл найруулга болон мэдээллийн багтаамжийн хувьд ч боломжийн хэмээн тооцож энэхүү сонинг бид сонгосон. Харин англи хэл дээрх мэдээллээ ихэвчлэн интернетээс авдаг. Хичээлд хэрэглэх материал учраас аль тааралдсаныг нь сонгохгүй тухайн хичээлийн сэдэв, агуулгад нийцэж байгаа байдал, шинэ үг хэллэг, шинэ мэдлэг олгох зүйл юу байгаа эсэх, оюутны мэргэжлийн чиглэлд хэр зэрэг нийцэж байгаа зэргийг тооцон үзнэ.

Дэлхийн мэдээг гадаадын эх сурвалжаас голдуу авч орчуулсан байдаг учир илүү анхаарал тавих шаардлага гардаг. Тухайн мэдээг орчуулсан орчуулагч сэтгүүлчийн эх хэлний болон гадаад хэлний мэдлэг, найруулан бичих чадвараас шалтгаалан чанар сайтай, заримдаа найруулга болхи, хэт модон орчуулгатай материалууд ч олон гардаг нь нууц бишээ. Зарим нэг алдаа ташаа найруулгатай эх сэдвээс энд жишээ өгүүлье.

Өдрийн сонин №123,124 2009.05.20

Билл Клинтоньг НҮБ-н тусгай төлөөлөгчөөр томиллоо.

... Б.Клинтон нь дэлхийн хамгийн ядуу оронд тооцогдох Гаит улсад тусламж дэмжлэг үзүүлэх асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулж байгаа юм байна.

Энэ өгүүлбэрт Б.Клинтонь ард “нь” илүүджээ. Мөн “тусламж дэмжлэг үзүүлэх асуудалд” гэснээс зүгээр л “тусламж дэмжлэг үзүүлэхэд” гэвэл илүү дээр байна. Мөн өгүүлбэрийн адагт “юм байна” гэснээс “байна” эсвэл “байгаа” гэвэл илүү тохирох ажээ.

Ер нь сүүлийн үед юм байна, юм гэнэ, юм байх гэсэн төгсгөлтэй өгүүлбэрүүд сонинд их

¹ МУИС-ийн ОУХС-ийн багш

гарч байна.

Заримдаа өмнө нь ямар өгүүлбэр бичсэнээ мартчихдаг бололтой. Мөн энэ мэдээнд:

“Өнгөрсөн жил тус улс байгалийн гамшигт нэрвэгдсэнээс ойролцоогоор 800 хүн амь үрэгджээ. Тус улсын эдийн засагт үүний улмаас нэг тэрбум ам долларын хохирол учраад байгаа юм.”

Эхний өгүүлбэрт байгалийн гамшгаас болж 800 хүн амь үрэгдсэн тухай өгүүлсэн харин дараагийн өгүүлбэрт нэг тэрбум ам долларын хохирол байгалийн гамшгаас болсон уу, эсвэл 800 хүн нас барснаас уу гэдгийг ойлгогдохооргүй болжээ. Энэ өгүүлбэрийг хоёр янзаар өөрчлөн засварласан. Үүнд:

1. Өнгөрсөн жил тус улс байгалийн гамшигт нэрвэгдсэнээс ойролцоогоор 800 хүн амь үрэгджээ. Гамшгаас болж тус улсын эдийн засагт нэг тэрбум ам долларын хохирол учраад байгаа”

2. Өнгөрсөн жил тус улс байгалийн гамшигт нэрвэгдсэнээс эдийн засагт нэг тэрбум ам долларын хохирол учиржээ. Мөн 800 гаруй хүн амь үрэгдсэн байна.

Мөн энэ дугаарт

Тэрбумтныг саятан хэмээн бичсэнд гомдолтой байна.

Америкийн тэрбумтан Дональд Трампыг сэтгүүлч Тимоти О Брайнд ихэд гомдоосон байна..... Ингэхдээ өөрийнхөө авсан эх сурвалжийг үндэслэн энэ тоог гаргасан гэдгээ тайлбарласан байна.

Үүнийг бид дараах байдлаар залруулав.

Америкийн тэрбумтан Дональд Трампыг сэтгүүлч Тимоти О Брайнд ихэд гомдоосон байна. Ингэхдээ авсан эх сурвалждаа үндэслэн энэ тоог гаргасан гэж тайлбарласан байна.

Мөн дугаарт

Дэлхийн эрүүл мэндийн байгуулгын чуулган эхлэв

Энэ удаагийн чуулганаар хэлэлцэх хамгийн гол асуудал нь ханиадны шинэ вирус А хүрээний H1N1 –тэй холбоотой асуудал юм.

Өгүүлбэрт асуудал гэдэг үгийг хоёр давтсан байсныг бид “Энэ удаагийн чуулганаар хамгийн гол нь ханиадны шинэ вирус А хүрээний H1N1 –тэй холбоотой асуудлыг хэлэлцэх юм” эсвэл “Энэ удаагийн чуулганаар хэлэлцэх хамгийн гол асуудал нь ханиадны шинэ вирус А хүрээний H1N1 –тэй холбоотой юм” гэж залруулсан.

Мөн дугаарт Энэтхэгт дундын тусгалтай пуужингийн туршилт амжилттай болжээ гэсэн гарчигтай мэдээлэлд болжээ гэдгийг хийв гэдэг үгээр сольсон. Учир нь пуужингийн туршилт байгаль дээр өөрөө болж байдаг ямар нэг үзэгдэл үер, газар хөдлөлт биш харин хүний оролцоотой хийгддэг учраас энд ийнхүү хийв/хийжээ гэдэг үгээр солих нь зүйтэй юм.

Сүүлийн үед сонингийн сэтгүүлч, сурвалжлагч, орчуулагч нар бичгийн хэл ярианы хэлийг хольж хутган, харь хэл дээрх эх сэдэвтэй хэт баригдсан ядуу модон орчуулга их хийж байгаа нь ганц энэ биш ээ.

Хамгийн гайгүй, боломжийн гэж тооцож болох сонин нь иймэрхүү алдаа мадагтай зүйл нийтэлж байгаа болохоор бусад нь ямар байх нь ойлгомжтой гээд хэлчихэд их хол зөрөхгүй байх.

Бүтэн нэг хичээлийн жилийн турш монгол хэлнээс англи хэлэнд орчуулах материалыг “Өдрийн сонин”-оос авч бэлдэж байх явцад тохиолдож байсан алдаа дутагдал бүрийг энд тоочвол нэг бүү хэл нэлээд хэдэн ном болох тул үүгээр өндөрлөө.

Нөхцөл байдал нэгэнт иймээс сонин сэтгүүл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гарч байгаа алдаа мадагтай зүйлийг олж, түүнийг засаж залруулж, зөвөөр ойлгох чадвар оюутандаа төлөвшүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Үүний тулд эх сэдвийг анхааралтай уншуулах хэрэгтэй. Тухайн хам сэдвийн өгүүлж байгаа санааг сайтар ойлгож ямар алдаа ташаарал байгааг олж мэдэх нь чухал.

Орчуулах сэдвийг орчуулгын ямар дадал эзэмшүүлэхийг зорьж байгаад нийцүүлж оновчтой сонгох, ингэхдээ эх сэдвийн хүнд хөнгөн, мэдлэгийн ямар хүрээнд хамаарсан байх зэргийг бодож үзэх хэрэгтэй.

Хэрвээ тухайн сэдэв нь өмнө нь судалсан оюутнууд сайн мэдэх сэдэв байвал орчуулга хийж эхлэх боломжтой, гэхдээ сэдвийг ерөнхийд нь мэдэх нь уншиж ойлгохоос огт өөр учраас бэлтгэл болгох үүднээс эхлээд амаар орчуулга хийлгэх нь дээр гэж үзэж байна.

Хэрвээ тухайн сэдэв өмнө нь судалж байгаагүй шинэ зүйл бол маш анхааралтай уншиж, тухайн сэдвийн талаар мэдээлэл цуглуулах, түүнтэй төстэй сэдэв унших, эсвэл эх сэдвийг орчуулсан орчуулгыг харьцуулан уншуулах арга илүү үр дүнтэй байдаг.

Зөвхөн сонин хэвлэлийн материал төдийгүй бусад эх сурвалжаас авч байгаа, очуулгын хичээлд хэрэглэх материалд дүн шинжилгээг лексик семантик түвшинд, үг зүй өгүүлбэрзүйн түвшинд, найруулга зүйн түвшинд, зөв бичгийн түвшинд, бүтээлч шийдлийн талаас нь, үгийг шилжүүлэх өөр үгээр хэр оновчтой сольсон байдлаас нь тус тус хийж байх нь зүйтэй гэж үзэж байна.

Номзүй

1. *Монгол-Англи толь. Charles Bawden*
2. *Oxford Mondar English-Mongolian Dictionary*
3. *Oxford Advanced Learners Dictionary*
4. *Өдрийн сонин №123,124 2009.05.20*